

**САНГИЙН САЙДЫН ДЭРГЭДЭХ  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТИН СТАНДАРТЫН  
ХОРООНЫ ТОГТООЛ**

2021 оны 03 дугаар  
сарын 23-ны өдөр

№ 11

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйл болон Сангийн сайдын 2016 оны 323 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Хорооны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт 1-ээр баталсугай.
2. ДНБХ-ны Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандартын зөвлөл (НБББОУСЗ)-өөс баталж гаргасан “Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандарт - 2017”-ын монгол орчуулгыг бүрэн эхээр нь баталсугай.
3. ДНБХ-ны Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс баталж гаргасан “Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн гарын авлага”-ын монгол орчуулгыг бүрэн эхээр нь баталсугай.
4. “Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандарт - 2017”, “Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн гарын авлага”-ын орчуулгыг хэвлэж, нийтэд түгээх арга хэмжээг 2021 оны 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлж, үр дүнг танилцуулахыг ММНБИнститут /Д.Нацагдорж/-д үүрэг болгосугай.
5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Ч.Чимидсүрэн/-т үүрэг болгосугай.

САНГИЙН ДЭД САЙД БӨГӨӨД  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТИН  
СТАНДАРТЫН ХОРООНЫ ДАРГА

С.МОНГӨНЧИМЭГ


  
 Нягтлан бодох бүртгэлийн стандартын хорооны  
 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 11 дүгээр  
 тогтоолын нэгдүгээр хавсралт

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТЫН СТАНДАРТЫН  
ХОРООНЫ 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

	<b>Хийх ажил</b>	<b>хугацаа</b>	<b>Хариуцах ажилтан</b>
1	НББАСХ-ны 2020 оны тайлан, 2021 оны төлөвлөгөөг боловсруулах	3-р сард	Б.Болормаа Хорооны гишүүд
2	<ul style="list-style-type: none"> <li>- НББАСХ-ны 2020 оны тайлан, 2021 оны төлөвлөгөөг хэлэлцэн, батлах</li> <li>- ДНБХ-ны Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан “Нягтлан бодох бүртгэлийн боловсролын олон улсын стандарт - 2017” -ийн орчуулгыг хэлэлцэн батлах</li> <li>- ДНБХ-ны Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)-өөс баталж гаргасан “Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн гарын авлага” (Хараат бус байдлын олон улсын стандартыг багтаасан)-ын орчуулгыг хэлэлцэн батлах</li> </ul>	3-р сард	Б.Болормаа Хорооны гишүүд
3	НББ-ийн сургалтын хөтөлбөрт хийсэн судалгааны тайлан, зөвлөмжийг НББ-ийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын захирлуудад танилцуулах уулзалт, ярилцлагыг (цахимаар) зохион байгуулах.	4, 5-р сард	Л.Дондог Г.Гантулга Д.Нямаа Б.Болормаа
4	НББ-ийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги боловсруулах болон төрийн өмчит компаниуд, төсвийн байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичгийн боловсруулалтад судалгаа, шинжилгээ хийх ажлын шаардлага, нөхцлийг судлах.	жилдээ	Б.Болормаа Ц.Наранчимэг Г.Гантулга
5	НББАСХ-оор батлагдсан стандартуудыг хэвлэх, борлуулах, давтан сургах чиглэлээр ММНБИ-ийн гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны тайлан сонсох.	7-р сард	ММНБИ Хорооны гишүүд
6	НББОУСЗ-ийн баталж гаргасан СТОУС-ын тайлбарууд болох СТОУТХТ-15, БТХ-5, нийт 20 тайлбарын орчуулгыг хэлэлцэн, батлах	7-р сард	Б.Болормаа Хорооны гишүүд
7	УСНББОУС 2021 оны хэвлэл дэх нэмэлт өөрчлөлтийн орчуулгыг хэлэлцэн батлах	11, 12-р сард	Хорооны гишүүд
8	Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт хийсэн (БШУЯ-тай хамтран) хяналт, шинжилгээ үнэлгээний үр дүнг болон их, дээд сургуулиудын НББ-ийн мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын нягтлан бодох бүртгэлийн мэдлэгт хийсэн хөндлөнгийн үнэлгээний үр дүнг танилцуулах	11, 12-р сард	Б.Болормаа
9	Нягтлан бодох бүртгэлийн стандартын хорооны хурлын бэлтгэлийг хангаж, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг гишүүдэд хүргүүлэх, хуралдааныг зохион байгуулах	Тухай бүр	Б.Болормаа